



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/46

Алтанбулаг

Хөдөө аж ахуйн ээлжит тооллого
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн “л” заалт, 20 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн “Хөдөө аж ахуйн тооллого явуулах тухай” 74 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн тооллогыг сумын хэмжээнд 2022 оны 06 дугаар сарын 06-наас 06 дугаар сарын 17-ны өдрийн хооронд багтаан зохион байгуулах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Х.Отгонжаргал
(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Ц.Саранцэцэг
(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүдэд: Н.Мөнхзул
(Суврага багийн Засаг дарга)

Б.Буяннэлзий
(Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

М.Оюунсүрэн
(Газрын даамал)

2.Комиссын бүрэлдэхүүнд ДААЛГАХ нь:

- а)Хөдөө аж ахуйн тооллогыг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллах.
- б)Тооллогын комиссоод ажиллах шалгагч, тоологч нарыг тооллогын сургалтанд бүрэн хамруулах.

в)Тооллого явагдах талаар сумын хэмжээнд сурталчилгааны ажил зохион байгуулж, тооллогын мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн өглөөний 09:00 цагт эхлүүлэх

Аймгийн Статистикийн хэлтсээс ирүүлсэн жагсаалтад орсон иргэн, аж ахуй нэгжийг тооллогод бүрэн хамруулах

д)Тооллогын үед өрх, аж ахуйн нэгж , байгууллагаас мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэж ажиллах, өөрсдөө шийдвэрлэх боломжгүй тохиолдолд дээд шатны комисст мэдэгдэж холбогдох арга хэмжээг авах

е)Тоологч, тооллогод ажиллагсдын халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах, аймгаас ирсэн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт зардлыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

ё)Тооллогын дүнг хуваарьт хугацаанд нь аймгийн Статистикийн хэлтэст хүлээлгэн өгөх

3.Хөдөө аж ахуйн тооллогод хянагч, тоологчоор ажиллах албан хаагчдыг хавсралтаар баталсугай.

4.Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын бэлтгэл ажлыг бүрэн хангаж, дээд байгууллагаас ирсэн чиглэлийн дагуу чанартай зохион байгуулж , заасан хугацаанд дүнг аймгийн Статистикийн хэлтэст мэдээлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч(Х.Отгонжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Н.ОТГОНЦОГТ